

2025 оны 04 дугаар
сарын 29 -ны өдөр

№: 01

Улаанбаатар
хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 25/06 дугаартай дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.НАВААН

2025 оны 04 дугаар
сарын 29 -ны өдөр

№: 02

Улаанбаатар
хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тогтоолын хавсралтаар батлагдсан цалин хөлсийг зохих журмын дагуу олгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардлыг энэхүү тогтоолын хавсралтад заасан төсөвт багтаан гаргах, зардлын зарцуулалтыг компанийн санхүүгийн тайлан тэнцэлд зохих журмын дагуу бүртгэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.НАВААН

“Улсын их дэлгүүр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын
02 дугаартай тогтоолын Хавсралт



**Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны зардлын төсөв**

№	Төрөл	Төсөв /Мян.төг/
1	ТУЗөвлөлийн ердийн гишүүний цалин урамшуулал	24,000.00
2	ТУЗөвлөлийн хараат бус гишүүний цалин урамшуулал	18,000.00
3	ТУЗөвлөлийн хурал зохион байгуулах төсөв	800.00
4	Нийт төсөв	42,800.00

2025 оны 04 дугаар
сарын 29 -ны өдөр

№: 03

Улаанбаатар
хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, компанийн дүрмийн 7.3.4 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг сонгосугай. Үүнд:
 - 1.1. Янсанжавын Наваан
 - 1.2. Алтангэрэлийн Норсмаа
 - 1.3. Хүрэлхүүгийн Эрдэнэбаатар
 - 1.4. Тэрбишийн Сарантуяа
 - 1.5. Сэнгэдоржийн Хосбаяр
 - 1.6. Жаргалын Дөлгөөн
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг сонгосугай. Үүнд:
 - 2.1. Мөнхнасангийн Дамирансүрэн
 - 2.2. Нанзаддоржийн Энхчимэг
 - 2.3. Мэндсоогийн Ганцэцэг
3. Холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм, дотоод үйл ажиллагааны дүрэм, журам зэрэг компанийн засаглалын тогтолцооны эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллахыг шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
4. Шинээр томилогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаарх мэдээллийг холбогдох эрх зүйн актад тусгасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид тус тус мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Өлзийбат/- д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.НАВААН